



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 9-р цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/33/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг Даланзадгад сум 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533552 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Аудитор: Н.Хулан Утас: 70533552 Цахим хаяг: khulann@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 9-р цэцэрлэг нь “Орон нутгийн бодлого шийдвэрт уялдуулан, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, үлгэр, ардын аман зохиолоор дамжуулан хүүхэд бүрийн жүжиглэх, дүрд хувирах чадварыг хөгжүүлж, сургалтын арга зүйд шинэ дэвшилт гаргах, хүүхдийг хөгжих явцад тулгарч буй бэрхшээлийг судлан түүнийг арилгах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Санхүүгийн байдлын тайлан		
	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	51.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,730.0
	Нийт хөрөнгийн дүн	1,781.3
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,345.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	371.2
	Үйл ажиллагааны зардлын дүн	498.4
	Үйл ажиллагааны үр дүн	-127.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-127.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,781.3
	Тайлант оны үр дүн	-83.6
	Эцсийн үлдэгдэл	1,697.7
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	371.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	371.2
	Үйл ажиллагааны ЦМГ	
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	324
	Урсгал зардал	324
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	324
	Улсын төсвөөс санхүүжих	290.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	33.7

Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллийг тулган баталгаажуулахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 129,199,252.6 төгрөгийн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 33,966,595.0 төгрөгийн худалдан авалтын мэдээлэл, 37,526,023.1 төгрөгийн хөрөнгө зарцуулах шийдвэрийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*”, 6 дугаар зүйлийн 6.4.4 “*таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг*”, 6.4.5 “*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*”, 6.4.8 “*бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр*,” заалтыг тус тус хэрэгжүүлээгүй эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

Тав. Аудитын үр дүн

5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	7	1,946.2	4	15.4	0	0	1	1,930.7	2	0.1
2	ТТЗ										
3	ТЕЗ										
	НИЙТ										

5.2 Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 1,946.2 сая төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс, 1,930.7 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 0.1 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан 15.4 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулсан.

Албан шаардлага:

- - Жилийн эцэст 1,730,008,160 төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, Шилэн дансны мэдээллийг шалгахад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 129,199,252 төгрөгийн 9 гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 33,966,595 төгрөгийн худалдан авалтын 5 мэдээлэл, 37,526,023 төгрөгийн хөрөнгө зарцуулах 10 шийдвэрийг тус тус мэдээлээгүй байна.

Зөвлөмж:

- Бараа материалын тайланг гаргахдаа шаардах хуудас, агуулахын бүртгэл бүрэн хөтлөөгүй, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар 50,000.0 төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Зургаа. Аудитын санал дүгнэлт /баталгаажсан хувийг оруулах/



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022.02.22 № 129

тантай _____-ны № _____-г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланзадгад сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Даланзадгад сумын 9 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгахдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жилийн эцэст 1,730,008,160.3 төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллого хийгээгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу 50,000.0 төгрөгийн гүйлгээ хийсэн, бараа материалын тайланг гаргахдаа шаардах хуудас, агуулахын бүртгэл бүрэн хөтлөөгүй, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгө, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

016090 37

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ЦЭРЭНБАЯР